

CHINGGIS

LAND DEVELOPMENT GROUP-NDR

МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Засгийн Газар, Эдийн Засаг, Хөгжлийн Яамнаас “Чингис Лэнд Девелопмент Групп-Шинэ Хөгжлийн Зам” ХХК-ны ажил хэргийн нэр хүнд, бүрэн эрхэнд удаа дараа бүдүүлгээр халдаж байгаад харамсч байна.

“Чингис Лэнд Девелопмент Групп-Шинэ Хөгжлийн Зам” ХХК нь компани 2012 онд Төрийн өмчийн хорооноос зарласан “Азийн авто замын сүлжээний АНЗ хурдны авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер”-т орж шалгаран Концесс эзэмшигч болсон бөгөөд 2014.03.09-ний өдөр тухайн үеийн Эдийн Засгийн Хөгжлийн Яамтай Концессын гэрээг гучин жилийн хугацаатай “Барих-Ашиглах-Шилжүүлэх” нөхцөлтэйгээр байгуулсан.

Манай компани нь тендерт шалгарснаасаа хойш “Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 1000 км хурдны авто зам”-ын ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, инженер геологи, геодези, гидрометрологийн судалгааны ажлуудыг олон улсын зөвлөх компаниудын тусламжтайгаар иж бүрнээр нь хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн 2014 онд БНХАУ-ын хэрэгжүүлж буй “Бүс ба Зам” санаачилгад Монгол улсаа төлөөлөн “Талын Зам” хөтөлбөрийг амжилттай бүртгүүлэн нэгдэн орсон. Ингэж чадсанаар Монгол улсын нийгэм эдийн засгийн хүндрэлтэй үед төр засагт зээл, баталгаа, батлан даалт зэрэг аливаа өрийн дарамт үүсгэхгүй байх механизмаар хөрөнгө оруулалтын асуудлаа шийдвэрлэсэн.

Гэтэл өнөөдрийг хүртэлх бүхий л хугацаанд төрийн өндөр албан тушаалтнууд манай компаний талаар олон нийтэд концессын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, төрд санхүүгийн дарамт бий болгох “барих-шилжүүлэх” нөхцөлтэй мэтчилэн худал мэдээлэл тарааж, удаа дараа хууль бусаар цуцлахыг завдаж ирсэнд харамсч байна. Манай компани гэрээний хэрэгжилтийн 10-н жилийн хугацаанд үүргээ бүрэн биелүүлж ирсэн бөгөөд эрх зүйн чадамжаа огт алдаагүй явж ирлээ.

БНХАУ-ын дарга Ши Жиньпиний үрилгаар 2022.11.29-ний өдөр МУ-ын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх төрийн айлчлал хийсэн. МУ-ын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хуулиудад зааснаар МУ-ын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд улсаа төлөөлж, олон улсын гэрээ байгуулах эрхтэй. Уг бүрэн эрхийнхээ хүрээнд хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг шинэ эринд хөгжүүлэх тухай хамтарсан тунхаг гаргасан. Уг тунхаглалын 8-р зүйлд “Талын Зам” үндэсний хөтөлбөрийг “Бүс ба Зам” санаачилгатай үялдуулан хэрэгжүүлэхээр тохиролцон гарын үсэг зурсан байдаг. ОУ-ын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвөл гуравдагч этгээд (хөрөнгө оруулагч тал)-ийн эрх ашиг хөндөгдсөн хэмээн үзэж ОУ-ын Арбитрийн шүүхэд хандахаа хариуцлагатайгаар мэдэгдэж байна.

“ЧИНГИС ЛЭНД ДЕВЕЛОПМЕНТ ГРУПП-ШИНЭ ХӨГЖЛИЙН ЗАМ” ХХК

2023.07.24